



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.09.07, БААСАН ~ №176 (975)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Ухаалгаар ашиглах өргөн боломж уул уурхайд байна

Сүүлийн 15 жилд нүүрсний экспорт 15 дахин өсчээ. >11

FT ШИЛДЭГ
НИЙТЛЭЛҮҮД ТАНД
ХҮРЧ БАЙНА >9, 10

Ипотекийг эрчимжүүлэх иргэдийн хүлээлт өндөр байна

Ипотекийн зээлийн шинэ журмыг энэ сард танилцуулна. >12

ZGM DAILY

FULL
ENGLISH PAGE
INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч “Бөхийн өргөө”-г төрийн өмчид шилжүүлэх албан бичиг ЕС-д илгээлээ.
ЗГ багш нараас ирэх даваа гарагаас ажил хаялтаа зогсоохыг хүсэв.
Таван намын төлөөлөл намын санхүүжилтийн талаар хэлэлцэж байна.
Шүүхийн захиргааны ажилчид тангараг өргөжээ.

ЭДИЙН ЗАСАГ

"Discover Mongolia" уул уурхайн татварын асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ.
Монголбанк наймдугаар сард 2866 кг алт худалдан авлаа.
Ипотекийн зээлийн шинэ журмыг энэ сард олон нийтэд танилцуулна.
ТОП-20 индекс 19928.79 нэгж болж, 0.58 хувиар буурчээ.



НИЙГЭМ

Зам, талбайн тогтоол усыг соруулах шуурхай таван бригад ажиллаж байна.
МХЕГ-аас ЕБС, цэцэрлэгийн хоолонд өөх тос, давс, сахар ихтэй хүнс хэрэглэхийг хориглов.
ЭМ-ийн сайд сурагчдыг өвлийн улиралд хоёр сар амраах санал гаргалаа.
Ази, Номхон далайн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд чуулж байна.

ДЭЛХИЙ

Хоёр Солонгос гурав дахь удаагийн дээд хэмжээний уулзалт хийхээр төлөвлөж байна.
ОХУ-ын хөдөлмөрийн яам албан газруудад хүүхдийн өрөө гаргах санал тавилаа.
Зоригчдынх нь бие муудсан Emirates-ын онгоцонд АНУ хөл хорио тогтоолоо.
Кансай нисэх буудлын ажиллагаа зогссон нь Японы аялал жуулчлалд дам хохирол учруулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.09.07



15°

2°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЖЭЛЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ЭРСДЭЛД ОЙРХОН 200 МЯНГАН ХҮҮХЭД БАЙНА



Эцэг, эхийн зөвшөөрөлтэй нийтлэв

Хүүхдийн эрхийг хангах, аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий албан тушаалтан, албан хаагч нар ямар хууль журам, стандарт хэрэгжүүлэхээ ч мэдэхгүй, хүүхэдтэй ажиллах арга зүйгүй байгааг мэргэжлийн хүмүүс онцолж байна. ►5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Шил архиа далдлаарай, ширээний бүтээлгээ солиорой

П.Батбөх
ЗГМ

Соц нийгмийн согогийг шүүмжилсэн “Ховор хүмүүс” гэж уран сайхны кино бий. Тус кинонд “Шинэ халатаа өмсөөрэй, ширээний бүтээлгээ солиорой” хэмээн нэгдлийнхэн аймгийн төлөөлөгчийг утгахад бэлтгэж байгааг өгүүлдэг нь үзэгчдийн сэтгэлд хоногшин үлджээ. Харин үүн лугаа үйл явдал энэ төрийн өнгөнд давтагдахын чинээ бодож яваа нь хэд бол.

Сүүлийн үед гэнэтийн шалгалтыг зарлан мэдэгдэж

байгаад явуулдаг арга барил эргэн дэлгэрч байгаа нь ЗГХЭГ-ын үйл ажиллагаанаас тод харагдах болов. Яамны ажилтан ажлынхаа гадна цаг бусаар амиа алдсан харамсалтай хэрэг төрийн албаны хариуцлага, ёс зүйг сайжруулах гэнэтийн шалгалт зайлшгүй хийх цаг үе ирснийг Засгийн газарт тулгаж орхисон гэлтэй. Хачирхалтай нь гүйцэтгэх засаглал гэнэтийн шалгалтыг зарлаж байгаад явуулдаг соц нийгмийн гажиг тогтолцоог сэргээн дэлгэрүүлж буй нь төрийн албаны чанарт хэр нийцтэй юм бол.

►3



Трампыг огцруулах тухай танхимын гишүүд нь ярьжээ

Деметри Севастопуло

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын танхимын гишүүд Үндсэн хуулийн заалтыг ашиглан түүнийг албан тушаалаас нь огцруулахаар ярилцсан тухай нэрээ нууцалсан албаны эх сурвалж New York Times сонинд бичсэн байна. Нэргүй өгүүллийг зохиогчийн нотолж буйгаар Үндсэн хуулийн 25 дугаар нэмэлтийг хэрэглэх тухай шивэр авир яриа гарсан аж. Уг заалтаар танхимын гишүүд конгресст хандаж, Ерөнхийлөгчийг огцруулах хүсэлтээ хүргүүлж болно. Гэвч Үндсэн хуулийн хямрал үүсэхээс сээрэмжлэн уг замыг сонгохоос татгалзсан байна.

Үүний оронд өндөр албаныхан Ерөнхийлөгчийн ёс суртахуунгүй хандлагын улмаас түүний зарим санаачилгыг эсэргүүцэх боломжийг хөнджээ. Энд “Бид засаг захиргааг амжилтад хүрээсэй гэж бодож байгаа. Түүний олон бодлого Америкийг хөгжүүлж, аюулгүй байдлыг бэхжүүлсэн. Гэхдээ бидний үүрэг бол улсаа эн тэргүүнд тавих явдал. Гэтэл Ерөнхийлөгч манай бүгд найрамдах улсын эрүүл байдалд хөнөөлтэй алхмуудыг хийсээр байна.

►9

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАДЕЛХАНЫ МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад барилгын салбар үүсч хөгжсөний 92 жилийн ой, барилгачдын өдрийг тохиолдуулан барилга, хот байгуулалтын салбарыг хөгжүүлэх үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн ахмадууд, тэдний үйл хэрэг, ажил мэргэжлийг залгамжлан хөдөлмөрлөж буй нийт барилгачдад чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсын хот, суурины хөгжил цэцэглэлтийг түргэтгэх, хүн амын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, барилга байгууламжийн зураг төсөл болон барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн жигд, найдвартай ажиллагааг ханган ажиллахад Та бүхний оюун ухаан, авьяас чадвар, идэвх зүтгэл, санаачилга, бүтээлч хөдөлмөр ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа гэдгийг цохон тэмдэглэхэд таатай байна.

Даяаршлын зуунд дэлхий нийтийн анхаарлыг татсан дулаарал, цаг уурын өөрчлөлт, хотжилт, барилгажилтаас үүсч буй сөрөг үр дагавруудыг арилгахад ногоон хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухаан, мэдээлэл технологийн хөгжлийг бүтээлчээр ашиглан бодлого үйл ажиллагаагаа шинээр тодорхойлоход хүргэж байна.

Утаа, агаарын бохирдлыг багасгах, газар хөдлөлтөд тэсвэр муутай орон сууцны барилгуудыг шинэчлэх, бага дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамжийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд амины орон сууцанд ипотекийн зээл олгодог болох, Түрээсийн орон сууц хөтөлбөрийг боловсрон

Улс төр

Намын санхүүжилтийг сонгуулийн бус үед ч хянах шаардлагатай

Төсвийн мөнгийг санал худалдан авахад зарцуулах ёсгүй

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Монголд хүчтэй, чадвартай манлайлагч эмэгтэйчүүд, залуучууд цөөнгүй ч улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүрэхэд санхүүжилт хамгийн гол бэрхшээл болж буйг парламентад суудалтай намуудын төлөөлөл нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байна. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Нээлттэй нийгэм форум хамтран зохион байгуулж буй “Оролцоонд суурилсан улс төр: Саад бэрхшээл, шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлэг өнөөдөр хоёр дахь өдрөө үргэлжилж байна. Тус хэлэлцүүлэгт улс төрийн таван намын 60 орчим төлөөлөгч оролцож байгаа юм.

“Улс төрийн санхүүжилтийг зөвхөн сонгуулийн үед ярих асуудал биш. Сонгуулийн бус үед ч санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй. Намуудын бүх шатанд уралдаан тэмцээн зохион байгуулах, шагнал урамшуулал өгөх, баяр тэмдэглэх зэргээр санал худалдаж авах үйл ажиллагаа байдаг. Мөнгөний эх үүсвэр нь хязгаарлагдмал, цөөн учраас намд хэн их мөнгө өгсөнд нь илүү боломж олдож байна. Гишүүдээсээ мөнгө татдаг, төрийн өндөр албан тушаал хашиж байгаа гишүүнээсээ хандив нэхэх дарамталдаг байдал арилахгүй бол эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн тэгш оролцооны талаар ярих бололцоогүй” гэж



Улс төрийн тэгш оролцоог хангахад санхүүжилт гол бэрхшээл болж буйг парламентад суудалтай намуудын төлөөлөл нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байна.

Б.Батдорж / ЗГМ©

Нээлттэй нийгэм форумын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг хэллээ.

Манай улсад парламентад суудалтай намуудад суудлынх нь тоогоор жилд 10 сая төгрөг олгодог. Энэ нь намуудын санхүүжилтийн 10 хүрэхгүй хувийг эзэлж буй. Тиймээс намууд санхүүжилт олохын тулд томоохон компаниудаас хандив авадаг нь улс төрийн тогтолцоог бүхэлд нь гажуудуулж буйг хэлэлцүүлэгт оролцогчид онцоллоо. МУБИС-ийн профессор Э.Гэрэлт-Од “УИХ-ын сонгуульд оролцогч эхлээд хэнээс санал авах гэж буйгаа ойлгох ёстой. Намынхаа гишүүдээс биш ард иргэдийн саналаар сонгогдох учраас урт



хугацаанд өөрийгөө, бодлогоо таниулах ажил хийх нь зүйтэй. Харин манайд сонгуулийн сурталчилгааны хугацааг маш бага зааж өгсөн учраас

богино хугацаанд өөрийгөө таниулахын тулд мөнгө чухал болчихоод байгаа. Ер нь улс төрийн санхүүжилт гэдэг зөвхөн сонгуулийн үеийн асуудал биш.

Сонгуулийн бус үед ч ил тод, “шилэн” байх ёстой” гэв.

Улс төрийн намын санхүүжилтийг цэвэр байлгахыг улс орон бүр зорьдог. Сүүлийн жилүүдэд олон улсад улс төрийн намуудыг бизнесийн бүлгүүдээс хараат бус байлгахын тулд төрөөс санхүүжүүлэх хандлага бий болсон. Ялангуяа, эдийн засгийн бололцоо тааруу ч манлайлах чадвартай залуусыг парламентад нэр дэвшихэд нь кампанит ажлын зардлынх нь зарим хэсгийг төсвөөс гаргадаг жишиг зарим оронд байдаг аж. Гэхдээ маш өндөр, зөв шалгуур тавихаас гадна мөнгөний зориулалтыг нь зааж өгч, хяналт сайн тавьдаг. Ингэснээр парламентад суудалтай намын залуучуудад

боломж нээгдэж, эрх мэдлийн төвлөрөл саарна гэж үздэг байна. Тухайлбал, Гүржид сонгуулийн кампанит ажлын зардлын 50 хувийг нь төсвөөс гаргадаг аж.

Бизнесийн бүлгийнхний санхүүжилтийг бууруулбал түүний орон зайг нөхөх эх үүсвэр нь төсөв, мөн иргэд байх боломжтой гэж судлаачид үздэг байна. Гэхдээ төсвөөс гарч буй мөнгийг эргүүлээд санал худалдаж авахад ашиглаж байна уу, зориулалтаар нь зарцуулж байна уу гэдэгт хатуу хяналт тавих ёстойг анхааруулсан юм. Хэлэлцүүлэгт оролцогчид намуудын санхүүжилтийг шилэн, цэвэр байлгахын тулд хуульд зохих ёсны өөрчлөлт оруулах шаардлага бийг хэлж байлаа. [ЗГМ]

ЕРӨНХИЙЛӨГЧ

“Монгол бөхийн өргөө”-г төрийн өмч болгох албан бичиг хүргүүлэв



С.Батсайхан / ЗГМ©

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол бөхийн өргөө”-г төрийн өмчид шилжүүлэх асуудлаар “Арга хэмжээ авах тухай” албан бичгийг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд илгээлээ. Уг албан бичигт “Монгол бөхийн өргөө” болон Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүний албан тушаалыг булаалдсан хэсэг хүмүүсийн зөрчил, тэмцэл туйлдаа хүрч, монгол хүн бүрийн хүндлэл, бишрэлийг хүлээж ирсэн үндэсний спорт, түүхт их өв соёлын маань нэр хүнд, үнэлэмжийг үгүйсгэн гутаах болсонтой холбогдуулан миний бие 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зөрчилдөгч талуудын төлөөлөл болсон нэр бүхий хүмүүст хууль ёсыг умартсан тэмцлээ таслан зогсоож, Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмынхаа хүрээнд асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх сануулга хүргүүлсэн боловч үр дүнд хүрсэнгүй. Зөрчилдөгч талуудаас ирүүлж буй бие биенээ үгүйсгэн харлуулсан өргөдөл, мэдээллүүд өнөө хир ч газрахгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд үүнийг авч үзвэл нийт зардлын

дийлэнх хувийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн байгуулсан “Монгол бөхийн өргөө”-ний гол өмчлөгч нь төр бийхээр байна. Иймд “Монгол бөхийн өргөө”-ний өмчлөлийн асуудалд анхаарал хандуулж, холбогдох хуулийн дагуу төрийн өмчлөх эрхийг хамгаалан, тус барилгыг төрийн өмчид хамааруулах ажиллагааг шуурхай зохион байгуулж, явц үр дүнг тухай бүр танилцуулан хамтарч ажиллана уу” гэжээ. Тэрбээр “Бөхчүүд болон бөхийн зүтгэлтнүүдийн хүрээнээс хальж, бөх сонирхогчдыг хүртэл талцуулах хэмжээнд хүрсэн энэхүү үйл явдлыг иргэд, олон нийт илт буруушааж, улсын төсвийн хөрөнгө, ард түмний хандив, тусламжаар байгуулагдсан Монгол бөхийн өргөөг төрийн мэдэлд авах ёстой гэдэг санал, шаардлагыг гаргах болсон нь зүй ёсны хэрэг бөгөөд анхаарч шийдвэрлэвэл зохих үндэслэл бүхий асуудал” гэдгийг мөн дурдсан юм. Олон нийтийн хөрөнгөөр эхлүүлсэн 1.1 тэрбум өртөгтэй “Монгол бөхийн өргөө”-ний барилгын 800 сая төгрөг буюу дийлэнх хэсгийг 1997 онд Засгийн газраас гаргаж байжээ. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Ядуурлыг бууруулах түлхүүр нь боловсрол

Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаарх Зүүн хойд Азийн олон талт чуулга уулзалт Улаанбаатар хотод хоёр өдөр үргэлжилж, өчигдөр өндөрлөлөө. Тус чуулга уулзалтад 10 гаруй орны төлөөлөгчид оролцсон юм. Энэ үеэр УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны харьяа Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хорооны дарга, УИХ-ын гишүүн А.Унраатай ярилцлаа.

-НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудыг Зүүн хойд Азийн орнууд хэрхэн биелүүлж байна вэ. Манай улс энэ зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлж, ямар шатандаа явна вэ?

-Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт улс орны хөгжлөөсөө шалтгаалаад янз бүр байна. Манайх шиг хөгжиж буй оронд ядуурал, боловсролын салбарын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүнд байгаа бол Япон, БНСУ-ын бэрхшээл өөр байх жишээтэй. Энэ чуулганаар улс орнуудын 2030 он хүртэл төлөвлөсөн нийгмийн салбарын зорилтуудыг хэлэлцлээ. Манай улсын хувьд бусдаас давуу тал ч байна, хоцорч яваа асуудал ч байгаа.

-Тухайлбал ямар давуу тал байна вэ?

-Монгол Улс Үндэсний хөгжлийн газар байгуулсан, тогтвортой хөгжлийн бодлогыг хууль болгож баталсан, Засгийн газрын хөгжлийн хөтөлбөр болох Гурван тулгуурт бодлого хэрэгжүүлж байгаа нь сайн жишээ, давуу тал юм. Мөн УИХ дотроо энэ асуудлыг хариуцах Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо байгуулсан. Өөрөөр хэлбэл, институцийн хувьд бид суурийг нь тавьсан. Энэ



бол сайн эхлэл. Гэхдээ хүндрэл, бэрхшээл их байна.

-Нийгмийн салбарыг хөгжүүлэхэд ямар асуудал хамгийн их хүндрэлтэй байна вэ?

Нийтлэлчийн булан

Гэнэтийн шалгалтыг урьдчилан зарладаг уламжлал тогтлоо

◀1 ЗГХЭГ-аас 13 яам, 12 агент-лаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шалгалт хийж, төрийн байгууллагын 830 өрөөнөөс согтууруулах төрлийн бүтээгдэхүүн 115, архи, виски, виноны шил 21 ширхэгийг илрүүлсэн. Урьдчилан сануулж, анхааруулж байгаад гэнэтийн шалгалт гэдэг нэр дор илэрсэн нь энэ шүү дээ. Мэдээж гэнэтийн шалгалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлсэн бол тоон үзүүлэлт үүнээс хувь илүү гарах байсан нь дамжиггүй. Мөн УИХ-ын эрхэм гишүүд өрөөндөө архи-дан согтуурч, согтуу хөлчүү байнга дайвж байдгийг өнгөрсөн сонгуулиар цацагдсан парламентын гишүүн асан Л.Эрдэнэчимэгийн бичлэг нотолсоор байтал энэ шалгалтаа Төрийн ордонд хийгээгүй нь бас хачирхалтай.

Урьдчилсан анхааруулгатай гэнэтийн шалгалт орон нутаг руу шилжих шийдвэр аль долоо хоногийн өмнө зарлагдсан. Долоо хоног гэдэг гэнэтийн шалгалтад бэлтгэхэд хангалттай хугацаа. Гэхдээ л ЗГХЭГ-ын дарга сайд аймгийн удирдлагуудтай цахим хурал хийх үеэрээ дахин сануулж, онцгой анхааруулав. Засгийн газраас ажлын хэсэг гарч аймаг, орон нутгийн төрийн байгууллагуудад согтууруулах ундаа, архины шилиний тооллого явуулах юм байх. Түүнд нь тааруулж шил, архиа нуугаарай, ширээний бүтээлгээ солиорой гэсэн сценари бэлтгэгдсэн байх болов уу. Мөн сайдтан шалгалтын хүрээнд аймгийн удирдлагуудын гадаад, дотоод айлчлал, аяллын зорилго, зардлыг давхар шал-гахаа бас л урьдчилан сануулсан мессеж илгээж байна лээ. Цаад санаа нь аялал, зугаалгынхаа баримт материалыг хуулийн хүрээнд болго гэсэн албан даалгавар гэлтэй. Ийм тохиол-долд анхааруулсаар байтал алдаа гаргавал хохь болох тул энэ шалгалтын дүн онцсайн гарах нь дамжиггүй. Дүн нь ойлгомжтой шалгалтад ажлын хэсэг томилж төсвийн мөнгө үрэх шаардлага байгаа ч уу, үгүй ч уу. Шалгуулагч тал хүлээн



Соц нийгмийн согогийг шүүмжилсэн “Ховор хүмүүс” киноны “Шинэ халатаа өмсөөрэй, ширээний бүтээлгээ солиорой” хэмээн дарга нарыг угтдаг шиг жишиг энэ төрийн өнгөнд давтагдаж буй нь харамсалтай.

Шил архиа далдлаарай, ширээний бүтээлгээ солиорой

авах зардлаас эхлээд ян тан бэлтгэхийн тулд төсвийн хөрөнгө зарцуулах нь ойлгомжтой.

Төрийн ордонд архидаж буй бичлэг байсаар атал яагаад шалгасангүй вэ

Уг нь шалгалт гэнэтийн байх тусмаа дүн нь бодит байдлыг илтгэдэг. Хувийн хэвшлийнхэн төрөөс явуулж буй гэнэтийн хяналт, шалгалтад байнга өрт-дөг болохоор хариуцлага нь

дээшилж, үйл ажиллагаа нь ч сайжирсаар байдаг.

Төрөөс хувийн хэвшлийг шалгахдаа нэгэн адил урьдчилан мэдэгддэг бол улс даяараа зөрчил дутагдалгүй цэмбийж байх биз. Харамсалтай нь хяналт шалгалтын ажил хувь, хувьсгалыг ялгаварлаж эсрэг, тэсрэг хэлбэрээр явагддаг болохоор төрийн байгууллагын шалгалтын дүн гялтайж, хувийнхны зөрчил халтайж харагддаг. Хариуцлагын тогтолцоог улс даяар сайжрууль гэж байгаа бол үүнийг өөрчлөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн хаалгыг тогшилгүй ордог хяналт, шалгалт төрийн захиргааны байгууллагад ч адил үйлчилдэг баймаар байна. Ядаж утас цохиж, урьдчилан

мэдэгдэлгүй очдог болчих. Ялангуяа, “ниргэсэн хойно нь хашхирч” буй энэ мэт шалгалтыг шууд утгаар нь гэнэдүүлж хийсэн бол төрийн сахилга, хариуцлагыг сайжруулахад сайн “гарын ав-лага” болох байлаа.

Борооны дараа шүхэр барих мэт эл шалгалтын арга барилыг аль эрт халах ёстой агал төрийн шат шатанд амь бөхтэй оршоор байгаа нь өнөө цагийн эмгэнэл.

Хөлбөмбөгийн талбайд хүүх-дийн амь эрсдэхэд сургуулийн орчны аюулгүй байдлын шалгалт боловсролын байгууллагуудыг сэрээсэн. Тогонд цохиулж хүүхэд эндсэний дараа эрчим хүчний салбарынхан “цочиж” хөдөлгөөн өрнүүлэх жишээний үйл явдлууд шилээ даран үргэл-жилсэн нь саяхан. Төрийн алба-

ны энэ мэт “орсон борооны араас цув нөмөрдөг” арга барил үргэлжилсээр байгааг салбар болгоноос харж болно.


НИТХ-аар Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагааг хэлэлцэх үед ч гэсэн өрнөөд өнгөрсөн үйл явдлын араас ажил зохион байгуулж байгаа тухай ярьж л байна. Цэцэрлэгт хүрээлэн гурван сар буужигнаж хууль бус, стандарт зөрчсөн олон үйл явдал болж, зах замбараагаа алдсаных нь дараа хийж хэрэгжүүлээгүй ажлыг намрын сэрүү орж хүний хөл татрах цагаар эхэлж байх жишээний. Дээр нь нэмээд соёл урлаг, аялал жуулчлал хариуцсан байгууллагуудыг олон нийтийг хамарсан арга хэмжээнүүд зохион байгуулахыг үүрэг болгож ч байх шиг. Урагшаа харж,

ирээдүйд гарах эрсдэлийг тооцож төлөвлөгөө гаргадаг болохоос өнгөрсөн цаг хугацааны араас зохион байгуулалт хийх нь хэр оновчтой “ноу хау” юм бол доо.

Ниргэсэн хойно нь хашхирах бус эрсдэлийг урьдчилан харж хяналт, шалгалт хийж хэвшвэл төрийн бодлого голдрилдоо явахын гол үндэс байлтай. Гэтэл төрийн сайд нь “одоо та нарыг очиж шалгана шүү” хэмээн ам мэдэн орилсны дараа шалгадаг жишиг тогтоож буй нь сайжрах бус хуурч, додомдохын хэлэлийг тавьж байна. Цаашлаад яам, агентлагийн удирдлагууд сармагчин лугаа дуурайн гэнэт шалгах бус урьдчилан зарладаг уламжлал халдварлавал төрийн албаны дампуурал тэр болох буй за. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

IV улирлын захиалга эхэллээ



Онлайн захиалга

- Улиралд: 5000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
- Жилд: 15 000₮ (248 дугаар)



Хэвлэмэл захиалга


- Улиралд: 30 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 60 000₮ (124 дугаар)
- Жилд: 120 000₮ (248 дугаар)



Хосолмол захиалга


(Хэвлэмэл + Онлайн)

- Улиралд: 32 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 65 000₮ (124 дугаар)
- Жилд: 125 000₮ (248 дугаар)



tdbpay үйлчилгээгээр цахим сонин худалдан авахдаа Та доорх QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг, утасны дугаараа** бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сониныг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:



2600092954

тоот дансанд мөнгөө тушаана уу.

Нийгэм

Улсын төсвөөс жилд гурван сургуулийг л автобусаар хангадаг

Ч.Дүйриймаа
ЗГМ

Оюутан, сурагчдын хичээл эхэлж нийслэлийн замын түгжрэл хэд дахин нэмэгдлээ. Томоохон уулзвар, зам бүрт замын цагдаа зохицуулалт хийж буй ч энд тэндгүй түгжрэлд бухимдсан иргэд.

Автомашины хөдөлгөөнийг дугаараар хязгаарлаж, зарим замыг өргөтгөж зассан ч автомашины тоо хэт их байгаагаас замын түгжрэл багасахгүй л байна. Улаанбаатарын хамгийн их түгжрэлтэй хэсэг бол сургууль орчмын бүс. Ялангуяа, хотын төвд байрлалтай нийслэлийн 23, 5, 3, 1 дүгээр сургууль болон “Сант” сургуулийн орчимд замын хөдөлгөөн хамгийн их саатдаг. Мөн БЗД-ийн 14 дүгээр сургуулийн орчим сургууль эхлэх, тарах үед хүнд нөхцөл үүсдгийг Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн мэргэжилтэн хэлж байна. Сүүлийн жилүүдэд яармагийн зам дагуу “British school of Ulaanbaatar”, 41 дүгээр сургууль болон бусад сургууль орчмын бүсэд түгжрэл ихээр үүсдэг болжээ. Үүний шалтгаан нь эцэг эхчүүд хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт нь автомашинаар хүргэж өгөх.

“Тэд машинаа заавал тухайн сургуулийнх нь ойролцоо эсвэл дэргэд тавих гэж зүтгэдэг. Үүнээс шалтгаалаад замын хөдөлгөөнд саатал учирдаг. Автомашинтай яваа эцэг, эхчүүд зам бөглөж зогсдог, алхаад орчих газарт залхуурдаг. Зам таглаад хэдхэн секунд зогсоход замын хөдөлгөөнд хэчнээн их саад учруулдаг тэд мэддэггүй” гэж Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн олон нийт, сургалт судалгаа хариуцсан мэргэжилтэн Х.Гансүх хэлэв. Уг нь үүнийг шийдэх олон улсад ч хэрэглэдэг, манайд ч хэрэгжиж буй шийдэл бий.

Хэрвээ сургууль, цэцэрлэгүүд бүгд хүүхдийн автобустай болчихвол замын түгжрэл



Нийслэлд 251 сургууль, 670 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 53 сургууль, хоёр цэцэрлэг л хүүхдийн автобустай байна.

Б.Батдорж / ЗГМ©

Сургуулийн нэг автобус 25-29 автомашиныг орлоно

багагүй буурна. Сурагчдын автобус 25-29 хүүхдийн суудалтай байх стандарт бий. Тиймээс хүүхдээ хүргэж өгөх байсан төдий тооны эцэг, эхчүүд замын хөдөлгөөнд оролцолгүй үлдэнэ гэсэн үг.

Уг нь улсаас цэцэрлэг, сургуулиудыг хүүхдийн автобустай болгохоор төсөв баталдаг. Гэхдээ жилд ердөө гуравхан сургуулийг л автобустай болгодог. Энэ жилийн хувьд ч мөн гурван сургуулийг автобустай болгохоор 400 сая төгрөг төсөвлөжээ. Гэхдээ одоогоор аль сургуульд олгох нь тодорхой болоогүй, судалж буй аж. Нийслэлд 251 сургууль, 670 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 53 сургууль, хоёр цэцэрлэг л хүүхдийн автобустай байна. Өнгөрсөн хугацаанд 123

автобус давхардсан тоогоор 5376 суралцагчийг сургууль, гэрийнх нь хооронд зөөжээ. Төрийн өмчийн бус сургуулиудыг эс тооцвол нэг сургуульд нэг л автобус ногдож байна.

Шар өнгө бусад өнгөнөөс 22 хувиар илүү хүмүүсийн анхаарлыг татдаг

Харин СХД-ийн “Хобби” сургууль хамгийн олон буюу 13 автобустай сайн жишээ бий. Тус сургуулийн сурагчдын

автобусууд хичээл тарах болон эхлэх цагаар 12 чиглэлд үйлчилдэг юм байна.

Нийслэлийн Боловсролын Газар, нийслэлийн Тээврийн Газар болон нийслэлийн Замын Цагдаагийн Газар хамтран хүүхэд тээвэрлэх автобусны үйлчилгээнд хяналт, шалгалт хийдэг. Энэ жил шалгалтад нийслэлийн долоон дүүргийн 40 сургуулийн 73 автобус хамрагдсаны 46 нь тэнцэж зөвшөөрөл авчээ. Харин 26 автобус нь өнгө болон бусад зөрчлийн улмаас тэнцээгүй үлдсэн аж. Эдгээр автобуст зөрчлөө арилгах шаардлага тавьсан бөгөөд энэ сарын 13, 14-нд ахин шалгалтахаар болжээ.

Нийслэлийн Боловсролын газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт, шинжилгээ,

үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Энхтайван “Сургууль, цэцэрлэгүүд хүүхэд тээвэрлэх автобустай байх шаардлагатай ч стандартад нийцээгүй автобус ашиглаж болохгүй. Хамгийн гол нь хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байх ёстой. MNS 6440:2014 стандартын дагуу сургууль, цэцэрлэгийн автобус шар өнгөтэй байх хэрэгтэй. Автобус шар өнгөтэй байснаар бусад өнгөнөөс 22 хувиар илүү хүмүүсийн анхаарлыг татдаг учраас ийм шаардлага тавьдаг. Мөн 12-оос доош жилийн настай автобусыг зөвшөөрдөг гэх мэт шаардлагууд бий. Энэ стандартад тэнцэх эсэхээс шалтгаалан автобусны тоо жил бүр өөр өөр байдаг” гэсэн юм.

Улаанбаатар хотыг 1975 онд анх байгуулахдаа 500 мянган хүн

амтай байхаар төлөвлөсөн байдаг. Харин өнөөдөр хүн ам 1.4 саяд хүрч, тэр хэрээр автомашины тоо ч өссөөр байна. Нийслэлд жил бүр 65 мянга орчим автомашин нийслэлд нэмэгдэж буй. Уг нь 1000 хүнд ногдох автомашины тоо 30-аас дээшгүй байх ёстой гэсэн үзүүлэлт байдаг. Хэрэв нэг хүнд ногдох автомашины тоо 30-аас дээш болвол тухайн хотын автомашинд хязгаарлалт хийх болон нийтийн тээврийн хэрэгсэлд давуу эрх олгох зэрэг арга хэмжээ рүү шилдэг. Харин Улаанбаатар хотын хувьд энэ үзүүлэлтийг хэдийн давсан. Тиймээс нийслэлийн бүх сургууль, цэцэрлэгийг зориулалтын автобусаар хангах нь замын түгжрэлийг бууруулах хамгийн хялбар шийдэл байж болох юм. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баарсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
З.Цэлмэг

УЛААНБААТАР 152 өрхийн эмнэлэгт тоног төхөөрөмж гардууллаа

Ч.Дүйриймаа
ЗГМ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдоор ахлуулсан ажлын хэсэг СХД-ийн 5, 6, 9-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаа. Энэ үеэрээ тус төвүүдэд

нэн шаардлагатай байсан нярайн шарлалт хэмжих багаж, зүрх судасны даралт хэмжигч, амьсгалын замын эрхтэн цэвэрлэх насос зэргийг өгчээ. Түүнчлэн нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 152 өрхийн эрүүл мэндийн төвд НЗДТГ, нийслэлийн Эрүүл мэндийн газраас 431 тоног төхөөрөмж

олгосон байна. Нийслэлийн Засаг дарга С.Батболд “Энэ жил өрхийн эрүүл мэндийн төвүүдийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилт тавин ажиглаж байна. Одоогоор төсвөөс байрны засвар үйлчилгээнд 15 сая, тоног төхөөрөмжинд таван сая төгрөг зарцуулаад байна” гэв. [ЗГМ]

БАЙР СУУРЬ БНСУ-д хууль бусаар ажиллаж, амьдарч буй иргэдэд виз олгохгүй

БНСУ-д хууль бусаар амьдарч, ажиллаж буй гадаадын иргэд, ялангуяа БНХАУ-ын иргэдийг албан ёсны визтэй болгоно гэж их хэмжээний мөнгө залилсан гэмт хэрэг удаа дараа бүртгэгджээ. Үүнтэй холбоотойгоор БНСУ-ын Цагаачлалын албанаас мэдэгдэл гаргалаа. Уг мэдэгдэлд “БНСУ-ын Засгийн газар хууль бусаар

ажиллаж, амьдарч буй иргэдийг эх оронд нь албадан буцаахаар ажиллаж байгаа. Харин тэдэнд я

ЗГМ: Зочин

Эрсдэлд ойрхон 200 мянган хүүхэд байна

Хүүхэд хамгаалал, хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой 180 гаруй стандарт бий

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

“Хүүхдийн эрх хамгаалал төв” ТББ-ын захирал Д.Ундраатай хүүхэд хамгааллын өнөөгийн байдал, хууль дүрэм анхан шатандаа хэрхэн хэрэгжиж байгаа талаар ярилцлаа. Тэрбээр өмнө нь хүүхдийн тусламж үйлчилгээний утас 108-ын захирлаар ажиллаж байв.

-Золгүй тохиолдлын улмаас амиа алдсан, гэмтэж бэртсэн хүүхдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж, олон нийтийг бухимдуулж байна. Зарим нь үүнийг хууль эрх зүйн орчинтой холбон тайлбарладаг. Энэ чиглэлээр олон жил ажиллаж буй та ямар байр суурьтай байдаг вэ?

-2017 онд 261 хүүхэд гаднын шалтгаант нөлөөллийн улмаас нас барсан. Харин энэ оны эхний зургаан сарын байдлаар дээрх шалтгаанаар 151 хүүхэд нас бараад байна. Нэг ёсондоо томчууд бидний, төрийн байгууллагуудын ажил үүргээ сэтгэлээсээ хийгээгүйн төлөөсийг ийм олон хүүхэд амссан байна.

Монгол Улс НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцид 1990 онд нэгдсэн. Ингэснээр насанд хүрсэн хүн бүр, Засгийн газар, бүх салбарын байгууллага хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэг хүлээсэн. Гэтэл бид Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) гэсэн ганц байгууллага руу дайрч, тэднээс ажлын үр дүн нэхээд байдаг.

Монгол Улсад 7000 гаруй стандарт байна. Үүн дотор хүүхэд хамгаалал, хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой 180 гаруй бий. Эдгээрийг хувь, хувьсгалын бүх л байгууллагад мөрдүүлж байж Монгол Улс хүүхдээ хамгаалж чадна.

УИХ-ын эмэгтэй гишүүд санаачлан хөөцөлдсөний ачаар 2017 онд хүүхэд хамгааллын зардлыг таван тэрбум болгон нэмэгдүүлж чадсан. Үүн дээр нэмээд 1.4 тэрбумыг улсаас төсөвлөөд өгчихсөн. Гэхдээ энэ 6.4 тэрбум төгрөг хангалттай хүрч байна уу гэвэл үгүй. НҮБ-ын Хүүхдийн сангийн хийсэн судалгаагаар Монголын 1.1 сая хүүхэд, тэр дундаа эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 200 мянган хүүхдийг бүгдийг хамгаалъя гэвэл 22 тэрбум төгрөг шаардлагатай гэж гарсан.

-Шаардлагатай санхүүжилтийн дөрөвний нэгийг олгоод байгаа юм байна. Энэ мөнгийг үр дүнтэй зарцуулахад хамтарсан баг болон анхан шатны нэгж хэр зэрэг ажиллаж байгаа бол?

-ГБХЗХГ төсөвлөж өгсөн мөнгөндөө тааруулад тодорхой хэмжээний ажил хийж байна. Гэтэл сум, баг, хороодод хүрч ажиллах хөл байдаггүй. Аймгуудад хүүхдийн асуудал хариуцсан 2-3 мэргэжилтэн л бий. Баян-Өлгий аймаг гэхэд 100 гаруй мянган хүнтэй, үүний 40 мянга орчим нь хүүхэд. Гэтэл хүүхэд хамгаалаар ажилладаг хоёрхон мэргэжилтэнтэй.

Монгол Улсын Засгийн газар хүүхэд хамгааллын чиглэлээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр багагүй ажил хийсэн. Тухайлбал, 2016 оны хоёрдугаар сард Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль баталж, дагаж мөрдөх дүрэм журам, хөтөлбөр үндсэндээ гүйцэж байна. Гэхдээ эдгээрийг хэрэгжүүлэх ёстой яам, агентлаг, анхан шатанд байгаа сумын Засаг дарга, ИТХ, хамтарсан баг гэж нэрлээд байгаа хуулиар үүрэг



С.Батсайхан / ЗГМ©

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО

	ГБХ-ийн гэмт хэргийн тоо	ГБХ-ийн зөрчлийн тоо	ХБ-т хүргүүлсэн албан бичгийн тоо	ХБ-аар үйлчилгээ үзүүлсэн гэр бүлийн тоо	Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан хүний тоо	Аюулгүй байдлын хамгаалалт авсан хүний тоо	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан хүний тоо	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	Эрх зүйн зөвлөгөө авсан хүний тоо	Холбон зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо
2018 оны I улирал	1960	4186	590	1548	1739	369	699	1381	439	1850	598
2018 оны II улирал	1430	2517	256	758	799	243	417	464	295	557	407
Нийт	3390	6703	846	2306	2538	612	1116	1845	734	2407	1005

ГБХЗХГ©



хүлээсэн нөхдүүдийг ажиллуулах механизм дутагдалтай. Хамтарсан багийг зангидаж ажиллах ёстой Засаг даргынх нь мэдлэг боловсрол дутаад байна.

-Та тодорхой жишээтэй хэлэхгүй юу?

“Хүүхдийн эрх хамгаалал төв” хагас жилийн хугацаанд 300 гаруй хамтарсан багийг чадавхжуулах ажил хийлээ.

Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүрийн үүрэг оролцоо чухал. Жишээ нь, ил задгай цахилгааны утас, онгорхой нүх зэрэг хүүхэд гэмтээж магадгүй аюултай нөхцөл байдлыг харсан бол хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдэгдэх хэрэгтэй. 108 утас зөрчлийг цааш холбөмбөгийн талбайн хаалганд хэзээ ч шийдэгдэхгүй.

МХЕГ-ын даргын 2017 оны арваннэгдүгээр сарын 1-ний А179 тоот тушаал байна. Энэ тушаалын дагуу сургалт, хүмүүжлийн байгууллагууд эрүүл ахуй, халдвар хамгаалал, гадна тохижилтын дүрмийг мөрдөх ёстой. Өнгөрсөн зун сургуулийнхаа хөлбөмбөгийн талбайн хаалганд хүүхэд даруулж үхсэнийг та бүхэн мэдэж байгаа. Хэрэв сургуулийн удирдлага МХЕГ-аас гаргасан дүрэм журмаа мөрдөж ажилласан бол нэг хүүхэд амь насаараа хохирохгүй байлаа. Нөгөө талаар мэргэжлийн хяналтын газрын хүүхэд хамгаалсан байцаагч нь баталсан журмынхаа чиглэлээр хэдэн сургууль, цэцэрлэгийг хянасан юм бэ. Журмаа хэрэгжүүлэх ажлыг огт хийгээгүй л байхгүй юу.

Би сая Сүхбаатар аймгийн сургуулиудын нийгмийн ажилтан, дотуур байрны багш нарт сургалт хийгээд ирлээ. Энэ журмаа мэдэхгүй байна. Энэ мэтээр салбар хоорондын уялдаа холбоо манай төрд маш их дутагдаж байна.

Монгол Улс хүүхэд хамгааллын чиглэлээр аян, зөвлөгөөн, хурал олныг хийж байгаа. Гэвч гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, явцын үнэлгээ хийх ажил хандуулж эхэлсэнд баярлаж байна. Гэхдээ хүүхэд хамгаалал бол салбар бүрийн уялдаа холбоо шаардсан ажил. ХНХЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ хүртэл тодорхой үүрэг хүлээсэн байгаа шүү дээ. БХЯ гэхэд дэргэдээ “Тэмүүжин өрлөг” гээд ерөнхий боловсролын сургуультай. Олон мянган эмэгтэй алба хаагчтай. Мөн хилчдийн үр хүүхэд гээд хил дээр амьдардаг олон хүүхэд бий. Гэтэл бүхэл бүтэн яам хүүхэд, эмэгтэйчүүд хариуцсан мэргэжилтэнгүй байна.

ГБХЗХГ-т хүүхдийн асуудал хариуцсан зургаахан хүн бий. Тэд нэг сая гаруй хүүхдийн асуудлыг хариуцах үүрэгтэй. Аймаг, дүүрэг дээр ч ялгаагүй, нэг юм уу хоёр хүн л байдаг. ХНХЯ-нд хүүхдийн асуудал хариуцсан ганцхан мэргэжилтэн бий гээд бод доо.

-Хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй албан тушаалтнуудын сэтгэл дутаад байна гэж таны ярианаас ойлголоо...
-Яг үнэн. Хүүхдийн хүчирхийлэл, хамгааллын чиглэлээр ажиллахад хүмүүсийн сэтгэлийн хандлага хамгийн чухал. Сум, хороо, анхан шатан дээр очиход “Мөнгөгүй болохоор ажил хийж мөнгөгүй хэрнээ сэтгэлээрээ ажиллаад, үр дүнд хүрээд байна. Гэтэл одоо бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нөхөн сэргээх

төв Монголд байхгүй хэвээр. Харин муу хэлэгддэг төрийн бус байгуулагынхан л хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусалж байна.

Сая Ерөнхийлөгч хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн байгууллага, Хүний эрхийн комиссынхныг дуудаж уулзлаа. Энэ үеэр сүүлийн хоёр жилд бага насны 298 хүүхэд бэлгийн хү

Мөнгөний урсгал

Shangri-La-гийн бүх төсөл урсгалаараа амжилттай хэрэгждэг гэвэл худал хэлсэн болно

Малайз гаралтай тэрбумтан Роберт Куок саяхан хэвлүүлсэн дүртгалынхаа нэг бүлгийг өөрийн байгуулсан Shangri-La Hotels & Resorts групптээ зориулжээ. Тэрбээр 1968 онд Сингапурын Орчард гудамжны хэсэгхэн газрыг худалдан авах гэрээний 10 хувийг эзэмшсэнээр хожим анхны Shangri-La -г сүндэрлүүлсэн түүхтэй. Өдгөө 94 настай, түүхий эдийн туршилагатай худалдаачин Куок тансаг зэрэглэлийн зочид буудлын үйлчилгэээ ашигтай бизнес хэмээн харжээ. Үүгээрээ тэрбээр дэлхий дахинд бизнесийн өөр нэгэн цонх нээж өгсөн юм.

Зочид буудал гэлтгүй бүх сал-барын бизнест ажилтан сонгон шалгаруулахад ур чадвар, үнэнч байдал, ачаалал даах чадвар гэсэн гурван үзүүлэлтийг анхаарах хэрэгтэй. Энэ гурвын аль нэг үзүүлэлт үгүй бол тэр хүнийг март.

Зочид буудал байгуулах явцад түүний жинхэнэ үнэ цэнийг унатар зардлаа танаж үл болно. Сайн чанарын гантиг чулуу, сайн чанарын мод, чадварлаг барилгачин гэх мэт бүх зүйл өөрийн гэсэн үнэ цэнэтэй. Хятадын эртний хэлц үгэнд “чанараа бууруул, барилгын материалаа тана” гэсэн байдаг. Хэрэв та ингэх бол хамрынхаа үзүүрээс огтолж буйгаас ялгаагүй хэрэг болно. Тухайлбал, хөгжиж буй зарим орны цементийн стандарт харьцангуй доогуур байдаг. Мэдээж та үүнийг хэрэглэхийг хүсэхгүй. Мөнгө хэмнэе гэвэл өртөг өсгөдөг үргүй зардлаас зайлсхийх хэрэгтэй. Сайн ажилтан хөлслөхгүй бол танаас хумслах, эсвэл гаднын гэрээлэгч нартай хамсаж хөрөнгө шамшигдуулах магадлалтай. Ийм зүйл байнга тохиолддог.



Куок сонирхогчдын түвшний өрсөлдөгчдийн талаар: “Тэд мөнгийг ус шиг урсгаж, угаалгын өрөөг алтан цоргоор чимэх мэтийн зүйлд зарцуулдаг. Хэнд ч хэрэггүй үйлдэл.”

Shangri-La-гийн нууц

үйлчлүүлэгчдэдэ дарамт, шахалт үзүүлэхийг хүсдэггүй. Би тэднийг манай хаалгаар аз жаргалтай, сэтгэл хангалуун гараасай гэж хүсдэг. Гэвч ширүүн өрсөлдөөний улмаас тааламжтай үнэ тогтоох боломжгүй учир бусад зочид буудал, тэр дундаа сүлжээнийхээ зочид буудлуудынхаа өмнөөс харамсаж явдаг. Хөгжиж буй орнуудад найз нөхөд, танил талаа түшиглэх явдал түгээмэл. Хэрэв танил тал нь Ерөнхий сайд эсвэл Ерөнхийлөгчийн суудалд заларвал мөнгөтэй болох завшаан олдоно. Тэдгээр дүр эсгэгчдийн нэг хүсэл бол тансаг зэрэглэлийн зочид буудал барих. Улмаар мөнгийг ус шиг урсгаж, угаалгын өрөөг алтан цоргоор чимэх мэтийн зүйлд зарцуулна. Хэнд ч хэрэггүй

ээзмшигч тал хоёул зөвхөн зочид буудлыг сайжруулахын төлөө хамтран ажиллах юм... Би Сингапур дахь Shangri-La-ийн ТУЗ-ийн хурал дээр байнга хэлдэг зүйлээ энд хэлэхийг хүсэж байна. “Бид гурван зүйлийг дараах дарааллын дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй. Зочид бууд-лын ажилтнууддаа санаа тавих, зочдоо халамжлах, хувьцаа эзэмшигчдээ анхаарах”. Яагаад танил тал нь Ерөнхий сайд эсвэл Ерөнхийлөгчийн суудалд заларвал мөнгөтэй болох завшаан олдоно. Тэдгээр дүр эсгэгчдийн нэг хүсэл бол тансаг зэрэглэлийн зочид буудал барих. Улмаар мөнгийг ус шиг урсгаж, угаалгын өрөөг алтан цоргоор чимэх мэтийн зүйлд зарцуулна. Хэнд ч хэрэггүй

одоогийн Shangri-La зочид буудал сүндэрлэж буй Чао Фраяа голын эрэг дээрх газрыг танилцуулж, хөрөнгө оруулалт хийсэн юм. Тиймээс заримдаа төслийн тал дээр эргэлзээ төрвөл өөрөөсөө илүү ухаалаг хүнтэй зөвлөлдөж, хамтран ажиллахыг санал болгох дээрх аргыг ашигладаг болсон. Хэрвээ надад “Энэ чинь бүтэхгүй” гэж хэлбэл бүтэхгүй л гэсэн үг. Энэст нь чи бусдын нүдээр зөв гарцыг олж харах болно.

ЯПОН

1980-аад оны эхээр Малайзын Nissin Sugar элсэн чихрийн үйлд-вэрийн хамтрагч маань Токиогийн далайн эрэг дээр Shangri-La зочид буудал барих санал тавив. Odaiba гэрэлт цамхгийн дэргэдэх

Хонконгод ирсэн юм. Японоор муухан ярьдаг тул Шибата түүний яриаг японоос англи хэл рүү орчуулж өгсөн юм. Бид 50:50 хувь хамтран эзэмшихээр тохиролцсон бөгөөд энэ нь түүнд давуу эрх олгохгүй гэж тооцсон юм. Мэдээж би 51 хувь эзэмшихийг хүссэн ч энэ нь ёс зүйгүй явдал болно.

Энэ төслийн төлөө би Солонгос руу 10 гаруй удаа очсон. Дөрөв, тав дахь удаагийн айлчлалын дараа би хүү Бьогээ төлөөлөгчөөр томилж, гурван долоо хоног тутамд нэг удаа төсөл рүү илгээж байв. Гэвч манай хамтрагч Квак биднээр жинхэнэ наадах шиг болж, зөвхөн угаалгын өрөөний дизайныг шийдэхийн тулд 5-6 цагийн турш маргалддаг байлаа. Тэр баахан цаасан дээр зураглал сараачиж байгаад хэсэг хормын

МЬЯНМАР

1993 онд миний дунд хүү Иан, Kuok Singapore-ийн бие бүрэлдэхүүний хамт Сингапурын Засгийн газрын төлөөлөгчдийг дагалдан Мьянмар руу айлчлал хийсэн юм. Энэ үед Мьянмар улс дэлхий дахинд үүд хаалгаа дөнгөж нээгээд байсан билээ. Хүү маань эргэж ирээд Мьянмарын хөгжилд хувь нэмэр оруулж, гэр бүлийнхээ зүгээс хөрөнгө оруулах туйлын хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Миний хувьд Мьянмарыг будааны худалдаагаар мэдэх боловч үнэндээ

Forbes Mongolia - ийн захиалга үргэлжилж байна.

Утас: 77074646

Хэрэв та дэлхийн хамгийн хөл хөдөлгөөнтэй гудамжинд 800 өрөөтэй зочид буудал байгуулсан бол өндөр ачаалалтай байх бүрэн бололцоотой бөгөөд санал болгож буй үйлчилгээндээ тохирсон ямар ч үнэ нэхэмжилж болно. Яг л загасчинтай адил.

Сүрэг загас утган авах урсгал хаана байна вэ? Та зочид буудлаа сүрэг загас утгах хамгийн өндөр магадлалтай газарт л байгуулах хэрэгтэй. Ямар ч урсгалгүй тогтуун далайд загасчлах хэрэггүй шүү дээ. Учир нь тэнд загас байхгүй.

Хэт өндөр үнэ нэхэмжилж заншсан зочид буудлууд надад таалагддаггүй. Харин Shangri-La-д нэр хүнд, стандартаас гадна урт хугацааны зорилго бий. Бид жил бүр ашигтай ажиллахыг хүсдэг, үнэхээр ашиг олдог ч басхүү

үйлдэл. Тэд үүндээ миний зар-цуулдгаас хоёр, гурав дахин их зардал гаргадаг. Shangri-La зочид буудлууд таван одтой зочид буудлын шаардлагад нийцэхүйц ухаалаг тохижилттой болохоос хэт чамин эсвэл гялгар биш. Би мөрөөдлийн цайз бүтээдэггүй.

Shangri-La-ийн гол онцлог бол эзэд нь өөрсдөө удирдлагаа атгадаг. Би мэргэжлийн менежерүүдийг үгүйсгэх гэсэнгүй. Гэхдээ бид эздийн шаардлага, зорилго болоод менежментийн багийн зорилгын нарийн ялгааг гаргасан. Тиймээс би эртнээс зочид буудал бүрт бодлогоын хэрэгжилт шалгах хороо байгуулсан. Тус хороонд буудлын ерөнхий менежер болон эзэмшигч талын нэг, хоёр хүн багтдаг. Хэрвээ ажил үүргээ зөв гүйцэтгэвэл менежмент болон

бус, харин байгууллагын ёс зүйн дагуу ажилчдадаа хүнлэг энэрэнгүй хандаж үлгэр жишээ үзүүлснээр тэднийг урамшуулж, зочид гийчид, харилцагчдад дээд зэргийн үйлчилгээ үзүүлэх урам зориг өгдөг. Хэрэв бүхнийг ухаалгаар гүйцэтгэж чадвал хувьцаа эзэмшигчдэдээ өндөр ашиг өгч чадна.

Shangri-La-гийн бүх төсөл урс-галаараа амжилттай хэрэгждэг гэвэл худал хэлсэн болно. Дөрвөн жилээ дурдахад Бангкок дахь эхний төсөл амжилттай хэрэгжсэн бол Токиогийн төсөл огт хэрэгжээгүй. Сүүл дэх төслийн х

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

МНВ	
09.00	“Эрт нахиалсан сарнай” Монголын ОАУСК 24 дүгээр анги
11.00	“Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр
14.00	“Устгах ажиллагаа” ОАУСК 9,10 дугаар анги
18.25	Шуранхайн нууцад нэвтрэхүй: Ганга нуурын галуу
20.00	“Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр
23.00	“Гэрэлтэй цонх” үдшийн хөтөлбөр
Bloomberg TV Mongolia	
07.00	"Суутнуудын намтар" нэвтрүүлэг
11.00	#MadelnMongolia" нэвтрүүлэг
14.00	"Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг
17.00	"Bloomberg Surveillance"
20.00	"Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
23.00	"Мөнгөний урсгал" давталт

БОЛОВСРОЛ	HD
07.05	"Ай Күү" хүүхэлдэйн кино 27, 28 дугаар анги
10.05	"Яг чам шиг охин" ОАК 1 дүгээр анги
13.05	"Кино миний амьдрал" нэвтрүүлэг
16.10	Хэрэглээний Хятад хэлний хичээл № 29, 30
21.05	"Мөсөн цирк Монголд" тоглолт 2 дугаар хэсэг
23.05	"Көсем" ОАК 1.57 дугаар анги

МОНГОЛTV	
09.30	"Тог тог тог" /season-6/ 14 дүгээр хэсэг
11.40	"Пэппа торой" /season-2/ 20-22 дугаар анги
14.00	"Ан амьтдын ертөнцөөр" / season-8/ 10 дугаар хэсэг
15.30	"Роботууд" хүүхэлдэйн кино
19.00	"Япон технологийн гайхамшиг" баримтат кино 6,7 дугаар хэсэг
00.00	"Оролт" ОАК /season-5/ 9 дүгээр анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 27
Намрын тэргүүн цагаан бич сарын найман цагаан мэнгэтэй, хар бар өдөр.
Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 06.19-19.20
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Төмөр

Аргын тооллын есдүгээр сарын 7, Сугар гараг. Билгийн тооллын 27, Үнэг одтой, хар бар өдөр.
Өдрийн наран 06.19 цагт мандан, 19.20 цагт жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой.

ОНЦЛОХ ҮЗВЭР

“Сэтгэл догдлуулсан орой”



Хөгжмийн зохиолч, продюсер, дуучин Б.Ангирмаа болон түүний охид энэ сарын 28, 29-нд Corporate concert hall-д сэтгэл догдлуулсан үдшийг өнгөрүүлэх гэж байна. Сэтгэлд шингэсэн олон дуу зохиосон Б.Ангирмаагийн Монголын орчин үеийн хөгжмийн урлагт мөнхрүүлж үлдээсэн "анхны" гэсэн тодотголтой олон бүтээл энэ үдэш үзэгчдэд хүрэх юм. Дурсамж сэргээсэн, бидний танил сайхан дуунуудаас гадна шинэ уран бүтээлүүд эгшиглэх гэж байна. Мөн продюссороор нь ажилласан олон шавь, хамтлаг, дуучид “Сэтгэл догдлуулсан үдэш”-ийн тайзнаа цуглана. On’n Off продакшны найруулж буй тус тоглолтын тасалбарын үнэ 40 мянга, 60 мянган төгрөгийн үнийн сонголттой. [ЗГМ]



Grandeur модерн баллет
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.09.28-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮30-40 мянга



Anniversary 60-th “Хоовон”
Хаана: Улаанбаатар палас
Хэзээ: 2018.09.14-нд
Тасалбарын үнэ: ₮ 30-40 мянга



“Чехийн хөгжмийн үдэш” тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2018.10.26-нд
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга

ЗГМ: СУДОКУ

			9	6			2
6							
	2					7	1
			2			1	9
			8			3	
	4	7					8
	1			4	2		3
	9			1			
	8			7			

9	7	2	3	8	1	4	5	6
6	3	8	2	5	4	1	7	9
5	1	4	7	6	9	8	1	3
7	8	5	4	3	2	6	9	1
3	4	1	5	9	6	2	8	7
2	6	9	1	7	8	5	3	4
1	2	7	9	4	5	3	6	8
8	5	3	6	1	7	9	4	2
4	9	6	8	2	3	7	1	5

(Өмнөх дугаарын хариу)

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2		3		4		5		6
				7						
8								9		
				10						
11	12		13			14	15		16	
17										

- БОСООГООР:**
- ОХУ-ын алдарт ачааны машин
 - Сүүгээр исгэж хийдэг цагаан идээ
 - Зууван бөмбөгт спорт тоглоом
 - Тахианы төрлийн жижиг шувуу
 - Монгол үндэсний бөхийн цээжин биеийн өмсгөл
 - Япон орныг нэрлэх нэр
 - Гэрийн тооныг бүтээх бүтээлэг
 - Юмны тодорхой байдал

- Хээр хазгай газар
- Шим тэжээл сайтай нүнжигтэй, чанартай

- загас
- Хөзрийн мод
- Швейцар улсын нийслэл
- Олноор нь үржүүлж

- ашиг шимийг нь хүртдэг шавж
- Шингэний эсрэг үг
- Дорноговь аймгийн сум

ХӨНДЛӨНГӨӨР:

- Улсын шигшээ багаа ихэвчлэн гадаадын иргэдээр бүрдүүлдэг Арабын улс
- Цагаан арстан цагаач иргэдийн зугаа болон хядагдсан Америкийн зэрлэг үхэр
- Сэлэнгэ аймгийн сум
- Нэгэн зүйлийн

Өм

Технологийн аваргуудын эсрэг шинэ дайралт эхлүүлээ

Тусгай хорооны байцаалт нь Вашингтон технологийн салбарт зохицуулалтаа чангатгаж буйг харуулав. > 10

Uber зорчигчийн аюулгүй байдлын шинэ технологи нэвтрүүлэв

Үйлчлүүлэгч, зохицуулагчдын шахалтад автсан компаниуд аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж эхэллээ. > 10

Jet Airways зарим ажилтныхаа цалинг тавьж дийлсэнгүй

Энэтхэгийн агаарын тээврийн компаниуд энэ санхүүгийн жилд 1.9 тэрбум ам.долларын алдагдал хүлээнэ. > 10

◀1

Ийм учраас Трампын томилсон олон албан тушаалтан түүний бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл буруу үйлдлийг нь сөрж, манай ардчилсан байгуулалтыг хамгаалахын тулд чадах бүхнээ хийхээр амласан” хэмээн бичжээ. Америкчууд танхимд хашир туршлагатай хүмүүс байгааг мэдэх ёстой. Бид юу болж байгааг сайн ухамсарлаж байгаа. Иймээс бид Трамп хүсэхгүй байлаа ч зөв гэж бодсон зүйлээ хийх болно. Засаг захиргааны албаны хүн сонинд ийнхүү бичсэний дараа ноён Трамп твиттертээ “Урвалт” гэдэг ганц үгээр хариулсан байна. Цааш нь хэрвээ ийм нэргүй хулчгар этгээд байгаа бол New York Times сонин түүнийг үндэсний аюулгүй байдлын үүднээс Засгийн газарт шилжүүлэн өгөх ёстой гэсэн



BBM©

Трампыг огцруулах тухай танхимын гишүүд нь ярьжээ

байна. Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч Сара Сандерс өгүүллийн зохиогчийг огцруулахыг уриалаад “хулчгар” хэмээн нэрлэжээ. Нэргүй өгүүлэл Washington Post-ын ахмад сэтгүүлч Боб Вудвардын “Айдас: Трамп Цагаан ордонд” гэдэг нэртэй Ерөнхийлөгчийг шүүмжилсэн ном гарахаас хэдхэн хоногийн өмнө нийтлэгдлээ. Энэ сэтгүүлч Ерөнхийлөгч асан Ричард Никсоныг огцруулахад хүргэсэн сурвалжилгуудыг Карл Бернштайнтай хамтран бичиж байжээ. Ирэх долоо хоногт хэвлэлтээс гарах номын тухай Wash-

Ноён Трамп нэрээ нуусан хүмүүс шүүмжилж байгааг “далд төр”-ийн явуулга, мэдээ задруулсан хэрэг гэв.

ington Post сонинд бичсэнийг үзвэл Батлан хамгаалахын сайд Жим Маттис Хойд Солонгосын асуудлаар зөвлөгөөний дараа ноён Трампыг тав, зургадугаар ангийн хүүхэдтэй зүйрлэсэн гэжээ. Цагаан ордны ажлын албаны дарга Жон Келли Засаг захиргааг “Галзуугийн хот” гэж нэрлээд ноён Трампыг “уяа нь алдуурсан тэнэг амьтан” гэж хэлсэн тухай дурдсан байна. Гэвч эш татагдсан хоёр хүн хоёулаа дээрх нотолгоог няцаав. Вудвардын номд түүнчлэн Трамп болчимгүй шийдвэр гаргахаас сэрэмжлэн туслахууд нь түүнээс ноцтой мэдээг

нууж байсан тохиолдлыг бичсэн байна. New York Times-г гарсан өгүүллийг зохиогч бас Цагаан ордон дахь асар эмх замбараагүй байдлын талаар дурдсан. Тэрбээр “Түүний хийсэн уулзалтууд сдвээс халих буюу замаасаа хазайдаг. Нэг зүйлийг дахин давтахаас гадна түүний түргэн зангийн улмаас сайн боловсруулаагүй, мэдээлэл муутай, заримдаа болчимгүй шийдвэр гаргаж, дараа нь буцаахад хүрдэг” гэж бичжээ.

Ноён Трамп нэрээ нуусан хүмүүс шүүмжилж байгааг “далд төр”-ийн явуулга, мэдээ задруулсан хэрэг гэж

удаа дараа мэдэгдсэн. Гэхдээ New York Times сонинд тавигдсан үзэл бодлын өгүүллийг бичигч Ерөнхийлөгчийг хазаарлахаар Засгийн газарт ажиллаж байгаа хүмүүсийг “тогтвортой төр”-ийн нэг хэсэг хэмээн тайлбарлажээ. Зохиогч цааш нь “Эмх замбараагүй байдлын эрин үед тийм хүмүүс байгаа нь сайн хэрэг. Гэхдээ америкчууд өрөөнд насанд хүрсэн хүмүүс байгааг мэдэх ёстой. Бид юу болоод байгааг бүрэн ухамсарладаг. Трамп хүсээгүй ч бид зөв зүйл хийхийг оролдож байна” хэмээн өгүүлсэн байна.



Шинэ зах зээлийн хувьцаа уруудаж эхэллээ

Эмма Данкли

Лхагва гарагт Турк ба Аргентиний валютын хямрал шинэ зах зээлүүдийн хувьцааны үнийг доош татаж, илүү өргөн хүрээг хамарсан хямрал үүсэх болгоомжлол төрүүлээ. Хөгжиж байгаа орнуудын 800 орчим томоохон компанийг багтаадаг FTSE-ийн шинэ зах зээлийн индекс өдрийн төгсгөлд 1.7 хувь доошилсон нь зургаан өдөр дараалсан уналт төдийгүй гурван долоо хоногийн хамгийн дээд үзүүлэлт боллоо. Ингэснээр тус индекс 2017 оны долдугаар сараас хойш хамгийн доод түвшинд иржээ. Индонезийн рупи 1998 оны Азийн хямралаас хойш хамгийн хямд үнээр арилжигдав. Түүнчлэн мягмар гарагт нийтлэгдсэн тайлангаар Өмнөд Африкийн эдийн засаг 2009 оноос хойш анх

удаа уруудсан дүнтэй гарсан тул тус улсын ранд мөн доошоо гулсав. Шинэ зах зээлийн EM ерөнхий индекс нэгдүгээр сарын дээд түвшнээс 20 хувиар унажээ. Шинжээчид энэ уналт нэг удаагийн цохилт уу эсвэл өргөн хүрээг хамарсан муу дохио юу гэдгийг таахыг оролдож байна. Pimco фирмийн стратегич Жене Фрида “Бид хэд хэдэн төсөөтэй цохилт харлаа. Гэвч энэ долоо хоногт илүү өргөн хэмжээнд шинэ зах зээлүүдийн хувьцааг зарж эхэллээ. Зарим хөрөнгө оруулагч бушуухан зарахын түүс болж байх шиг байна” гэжээ. Турк ба Аргентиний асуудал хамгийн эмзэг байсан бөгөөд цаашид халдварлаж болзошгүй юм. Хөрөнгө оруулагчид хөгжиж буй орнуудын валют, бонд, хувьцааны эзэмшлээ багасгахыг эрмэлзэж буй

шинж ажиглагдаж байна. Туркийн лир ба Аргентиний песо сүүлийн үед жаахан тогтворжиж JP Morgan-ы валютын индекс 0.3 хувь дээшилсэн боловч уг өсөлт хөгжиж буй орнуудын хөрөнгийн биржүүдэд нөлөөлсөнгүй. Лхагва гарагт хамгийн их алдагдал хүлээсэн хувьцаанууд Индонези, Саудын Араб, Нигери болон Хонконгийнх байв. Ийм арилжаатай давхцан Европын хувьцаа 0.9 хувь, S&P 500 индекс 0.3 хувь ухарсан явдал цаашид халдвар тархаж болзошгүй гэсэн айдас төрүүлэв. State Street Global Markets фирмийн шинжээч Двайфор Эванс “Хүмүүс одоо тухайн үеийн онцлогоос цааш харж байна. Эдийн засагт хамгийн их халгаатай ерөнхий тархалт халдварыг ажиглаж байна” гэжээ. Дөрөвдүгээр сараас ам.доллар

чангарсан явдал зарим шинэ зах зээлийн орнуудад асуудлыг хөөрөгдсөний дээр ам.доллараар нэрлэгдсэн өрийн хэмжээ сүүлийн арван жилд хоёр дахин өсөж, 3.7 их наядад хүрчээ. Түүнчлэн АНУ-ын бодлогын хүү өсөж, Холбооны нөөц аажмаар тэнцвэрээ сайжруулж байгаа нь ам.долларыг дэмжихийн сацуу шинэ зах зээлд дарамт учруулж байгааг шинжээчид тэмдэглэсэн байна. Аха хөрөнгийн сангийн менежер Марк Тинкер “Зах зээлд бидний одоо ажиглаж байгаа зүйл бол АНУ мөнгөний бодлогоо чангатгасны зүй ёсны үр дүн” хэмээн тайлбарлав. Үүний зэрэгцээ худалдааны зөрчил ч мөн дэлхийн эдийн засгийг удаашруулж байгааг шинжээчид хүлээн зөвшөөрсөн юм.



Хятадын технологийн хөрөнгө оруулалт АНУ-ын хаалттай тулав

Дон Вейнланд

Массачусеттс мужид байрладаг Nantero компани санах ойн чипээ зах зээлд гаргахын тулд бараг хорин жил зарцуулсан. Гаргаад эхэлмэгц Хятадын улсын хөрөнгө оруулагчид старт-апын зарим хэсгийг гартаа авчээ. Эднийх дөрөвдүгээр сард 30 сая ам.доллар босгохоо зарлахад хувийн мэдлийн компанид Хятадад хагас дамжуулагчаар тэргүүлдэг улсын SMIC компаниас мөнгө орж ирсэн байна. Түүнчлэн 15 тэрбум ам.долларын хөрөнгөтэй бөгөөд дотоодын чип үйлдвэрлэлийг дэмжиж, ирэх 10 жилд АНУ-ыг гүйцэхэд туслах зорилготой Хятадын улсын сан оролцжээ. Nantero-д хөрөнгө оруулсан явдал Хятадын сангаас АНУ-ын технологид оруулсан мөнгөний

дээд хэмжээг тогтоож, салбарын хувьд томоохон хөрөнгийн эх үүсвэр болсон. Гэвч үндэсний аюулгүй байдлыг судлагчид иймэрхүү хэлцэлд Хятадын улсын санг ашигласан явдал дэлхийд хамгийн чухал технологийн эхлэл Бээжингийн гар дүрснийг харуулж, Хятад, АНУ-ын худалдаа, технологийн дайны гол асуудал болж байна. Гадаад хөрөнгө оруулалтын эрсдэлийн тухай хууль наймдугаар сард хэрэгжиж эхэлсэн. Үүний дагуу АНУ-ын засаг захиргаа уг эрсдэлийг нарийн шалгаж тооцох ба эмзэг технологид оруулах багахан хөрөнгийг хүртэл хаах эрхтэй болжээ. Вашингтон дахь Hogan Lovells хуулийн фирмийн ажилтан Аарон Катлер “Засгийн газар жижиг хөрөнгө оруулалт



Технологийн аваргуудын эсрэг шинэ дайралт эхлүүллээ

Ханна Кюлер, Ричард Уотерс

АНУ-ын хууль зүйн яам шударга өрсөлдөөн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх асуудлаар технологийн компаниудыг мөрдөн шалгах гэж буйгаа анхаарууллаа. Google, Facebook, Twitter гишгисэн мөрөө эргэж харах ёстойг АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп өнгөрсөн долоо хоногт сануулсны дараа энэхүү анхааруулга гарч байна.

Facebook-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал Шерил Сандберг, Twitter-ийн гүйцэтгэх захирал Жэк Дорси нар АНУ-ын сонгуульд ОХУ хөндлөнгөөс оролцсон асуудлаар Сенатын тусгай хороонд мэдүүлэг өгөв. АНУ-ын ерөнхий прокурор Жефф Сешнс технологийн аваргуудыг шалгах аа мэдэгдсэн нь эрх баригчид шинэ дайралт эхлүүлэх гэж буйн дохио болов.

Сошиал мэдээллийн платформууд “өрсөлдөөнд саад учруулж, үзэл бодлоо чөлөөтэй солилцох явдлыг санаатай хавчиж байж болзошгүй” тул асуудлыг муж улсын ерөнхий прокуроруудтай хамтран хэлэлцэхээ ноён Сешнс мэдэгдлээ. Өнгөрсөн долоо хоногт ноён Трамп Google, Facebook, Twitter-ийг баруун жигүүрийн байр суурь хавчин боомилсон хэрэгт буруутгасан. Консерватив үзэл бодлыг мушгин гуйвуулсан зүйл байхгүй хэмээн компаниуд хариу мэдэгдэв.

Twitter-ийн зарим жиргээ “ялгаварлан гадуурхсан, хууль бус шинжтэй” байгааг мөрдөн шалгана гэдгээ АНУ-ын Ерөнхийлөгч долдугаар сард



мэдэгдсэн юм. “Тун эвгүй газарт мөрөө үлдээцгээж буй” Google, Facebook, Twitter-ийг “мэдээтэй байгаарай” хэмээн ноён Трамп өнгөрсөн долоо хоногт анхааруулсан юм.

Ноён Дорси лхагва гарагт Эрчим хүч, худалдааны танхимын комиссоос тавьсан цензур, контентын бодлоготой холбоотой олон асуултад дөрвөн цаг хариу өгчээ. Ерөнхийлөгчийн жишээг дагалдан Бүгд найрамдах намын олон гишүүн Twitter-ийг консерватив байр суурь мушгин гуйвуулсан хэрэгт буруутгаж

байна.

Twitter-ийн босс өөрийгөө хараат бус, бие даасан сонгогч, Ардчилсан, Бүгд найрамдах намыг дэмжигч айлын хүүхэд гэдгээ тайлбарласан юм. Twitter-ийн контенттой холбоотой байцаалт нь Бүгд найрамдахчууд үзэл бодлоо бэхжүүлэх оролдлого хэмээн дээрх танхимын комиссын бүрэлдэхүүнд багтдаг Ардчилсан намын гишүүд үзлээ.

Сошиал медиа компаниудын хүч нөлөөтэй холбоотой түгшүүр ихсэж байгааг ноён Дорси хүлээн зөвшөөрсөн. “Биднийг нийтэд

зориулсан талбар хэмээн хүлээн авч буй хүмүүс үүндээ тохирсон юмыг л хүснэ” хэмээн тэрбээр тайлбарлав. Иймд “үнэний зууч бол, бичлэгүүдээ зохицуул гэсэн шаардлага Twitter-т тулгах нь аюултай” хэмээн ноён Дорси өгүүлэв. Зохисгүй контентыг хэрэглэгч нар тэмдэг тавихаас нь өмнө илрүүлэх зэргээр Twitter-т өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаагаа захирал мөн дурдлаа. Либерал үзэл хүчтэй Сан-Францискогоос өөр газраас ахиу ажилтан хөлслөх талаар ч компанийн удирдлага эргэцүүлж

байна.

Хууль бус мансууруулах бодисын наймаачид бараагаа сошиал сайт ашиглан борлуулах тохиолдолд компаниудад хариуцлага хүлээлгэх саналыг Сенатын мөрдөн байцаалтын үеэр гаргасныг Facebook, Twitter хоёр эрс няцаалаа. Хэрэглэгчээс үүсгэсэн бараг бүх контентод уг хоёр компани АНУ-ын харилцаа холбооны ёс журмын хуулийн 230 дугаар заалтын дагуу хариуцлага хүлээдэггүй.

Гэхдээ жилийн өмнө Конгресс эмэгтэйчүүдийг наймаалахыг

сурталчилсан контентыг уг заалтаас хассан юм. Сошиал мэдээллийн компаниуд мансууруулах бодисын наймаанд ч хариуцлага хүлээх нь зүйтэйг Сенатын гишүүн Жо Манчин лхагва гарагт анхааруулж байлаа.

Компаниудын үйл ажиллагаа 230 дугаар заалтад тулгуурлаж байгааг хатагтай Сандберг, ноён Дорси нар Сенатын байцаалтын үеэр тайлбарлав.

Дээрх хуулийн 230 дугаар заалт байхгүйсэн бол Twitter үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам хязгаарлахаас аргагүй хэмээн ноён Дорси үзэж байна. Уг заалт л Facebook-д “үүрэг хариуцлагаа ихэсгэлгүйгээр хууль бус контент илрүүлэх боломж олгож байгаа”-г хатагтай Сандберг мэдэгдэв.

АНУ-ын сонгуульд ОХУ оролцсон тухай асуудлаар Сенатын тусгай хорооны байцаалт нь Вашингтон зарим зөрчилт нөхцлийг харгалзалгүйгээр технологийн салбарт зохицуулалтаа чангатгаж буйг харуулж өглөө.

“Сошиал мэдээллийн салбарт зэрлэг өрнөдийн үе эцэс болж байна. Цаашид асуудлыг та нар үзэмжээрээ шийдэж явна гэдэгт би хувьдаа эргэлзэх байна. Конгресс энэхүү асуудлаар шийдвэр гаргах байх” хэмээн тус хорооны дэд тэргүүн, Ардчилсан намаас Сенатад сонгогдсон Марк Уорнер байцаалт эхлэхийн өмнө өгүүлсэн юм. Лхагва гарагт Twitter-ийн хувьцааны үнэ 6.1 хувиар унаж 32.73, Facebook-ийнх 2.3 хувиар буурч 167.18 ам.доллар боллоо.



Uber зорчигчийн аюулгүй байдлын шинэ технологи нэвтрүүлэв

Шэннон Бонд

Тээврийн хэрэгсэл удаан хугацаагаар зогсох юм уу осолдож болзошгүй үед жолооч, зорчигч нартай холбогдох боломжтой болсноо Uber лхагва гарагт мэдэгдлээ.

Дэлхийн райд шеринг компаниуд аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавьж буй үед гарсан уг мэдэгдэл Сан-Францискод төвтэй Uber хэрэглэгчдийн итгэлийг олж авахаар чармайж буйн илрэл болов.

БНХАУ-д Didi Chuxing ашигладаг жолооч нар хоёр ч эмэгтэйн амь хөнөөсөн хэргийн дараа райд шеринг салбар дахь халдлага хүчирхийлэл дэлхийн нийтийн анхаарлыг татаж эхэллээ.

Салбарт тэргүүлэгч Didi, Uber болон АНУ-ын Lyft зэрэг бусад өрсөлдөгч нар машин мөргөлдөхээс эхлээд хүчирхийлэл, аллага хүртэлх аюулгүй байдалтай холбоотой төрөл бүрийн бэрхшээлийг шийдвэрлэхээр олон жил ажиллаж ирлээ.

Бэрхшээл шинэ зүйл биш. Харин даян дэлхийн үйлчлүүлэгч, зохицуулах байгууллагуудын шахалтад автсан компаниуд

аюулгүй байдлын асуудлыг нэн тэргүүнд тавих болсон нь шинэлэг юм. Uber, Lyft хоёр ажил үйлчилгээний үед гарч буй аюулгүй байдалтай холбоотой ослын статистикийг нийтэд ил тод мэдээлэхээр шийдээд байна.

“Бид Uber-ийг дэлхийд хамгийн аюулгүй хөдөлгөөнт платформ болгоно” хэмээн дуулиант хэргийн дараа буюу жилийн өмнө компанийн удирдлагад гүйцэтгэх захирлаар орж ирсэн Дара Хосровшахи амлав.

Ноён Хосровшахи албан тушаалдаа ороод жилийн ой тохиож буй үетэй зэрэгцүүлэн аюулгүй байдлын хэд хэдэн шийдэл хэрэгжүүлэх гэж байгаагаа Нью-Йорк хотноо зохион байгуулсан арга хэмжээний үеэр мэдэгдсэн юм. Тээврийн хэрэгсэл хэвийн бусаар зогсох, эс бөгөөс осол гарч болзошгүй үед жолооч, зорчигчидтой холбоо барих, машины автомат бүртгэлээс зорчигч авсан, буулгасан хаягийн мэдээллийг устгах зэрэг шийдэл үүнд багтжээ.

Uber нь оны эхээр аюулгүйн зарим шинэ бүтээгдэхүүн танилцуулсан. Тус компани яарал-

тай тусламжийн үйлчилгээтэй шууд холбох товчлуурыг аппликэйшндээ нэмж өгсөн нь тавдугаар сараас АНУ-д нэвтэрчээ. АНУ-ын Вашингтон, Бостон зэрэг хот, Мексикт жолооч юм уу зорчигч уг товчлуурыг дарах тохиолдолд машины байршил, улсын дугаарыг яаралтай тусламжийн үйлчилгээний диспетчерт мэдээлнэ.

Энэтхэгт 2015 онд жолооч нь эмэгтэй зорчигчийг хүчиндсэн хэрэг гарсны дараа Uber-ийн үйлчилгээг түр зогсоосонтой холбогдуулан тус компани “аюулын харанга дэлдэх товчлуур” анх санаачилсан юм.

Уг хэргээс тусдаа Хятадын Didi компани зорчигчийг шууд цагдаагийн газартай хол

Эдийн засаг



С.Батсайхан / ЗГМ©

16 дахь удаагийн Discover Mongolia чуулганд 600 гаруй төлөөлөгч оролцлоо.

Ухаалгаар ашиглах өргөн боломж уул уурхайд байна

Сүүлийн 15 жилд нүүрсний экспорт 15 дахин өсчээ

Г.Байгал
@baigalZGM

ТАНХИМ ДҮҮРЭН ОРОЛЦОГЧИДТОЙ ЧУУЛГАН

Уул уурхайн чуулган, уулзалтаар дүүрэн долоо хоног шувтрах гэж байна. Ар араасаа цуварсан ажил хэрэгч чуулгануудад энэ салбарынхан алжааж буй шинж алга. Өнгөрснөө эргэн харж, ирээдүйг хэлэлцэхийг хүссэн оролцогчдын тоо чуулганаас чуулганд нэмэгдэж буйг зохион байгуулагчид нь онцолж байна. Сүүлийн хэдэн жил болсон хөрөнгө оруулагч ховор, эл хуль чуулганууд ард хоцорчээ. 16 дахь удаагийн Discover Mongolia чуулган гэхэд 600 гаруй төлөөлөгч оролцлоо.

Шинэ долоо хоног, шинэ сар, шинэ улирлыг нээсэн “Coal Mongolia 2018” чуулга уулзалт нүүрсний салбарыг нөмөрсөн яриа хэлэлцээгээр өрнөсөн. Тэгвэл мөр залган болж буй Монголыг таниулах ээлжит суваг болох “Discover Mongolia” чуулганаар нүүрсээр зогсохгүй алт, зэс, уран зэрэг эрдэс түүхий эдийн хайгуул, олборлолтыг хамтад нь хөндсөн юм. Ялангуяа, бусад салбараасаа хоцорч яваа хайгуулын салбар чуулганы хамгийн халуун сэдэв байв. Уул уурхай, улс орны хөгжлийн урд нь явах учиртай хайгуулын салбар аль хэдийнэ ард хоцорсныг албаныхан ч хүлээн зөвшөөрч байна. Гэтэл дэлхий даяар хайгуулын салбарт хөрөнгө оруулалт татахад улам амаргүй болсоор. Учир нь хиймэл оюун ухаан, цахилгаан автомашины салбар зэрэг хайгуултай хөрөнгө хуваах шинэ талбар бий болсноос өрсөлдөөн улам ширүүсч байна. Тиймээс хоцорч яваа бид өрсөлдөх чадвараа өсгөхгүйгээр хол хаягдаж магадгүй байна.

ХАЙГУУЛЫГ ӨНГӨТ МЕТАЛЛ ӨНГӨЛЖ БАЙНА
Таван жил дараалан унасан дэлхийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үнийн өсөлттэй уралдан өнгөрсөн оноос эргэн сэргэж, жилийн дүнгээр 61 хувиар нэмэгдсэн байна. S&P Global Market Intelligence-ийн тооцоогоор өнгөрсөн онд өнгөт металлын хайгуулын зардал 8.4 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь уул уурхайн салбарын оргил үе болох 2012 оныхоос хоёр дахин бага боловч 2016 онтой харьцуулахад бараг нэг тэрбум ам.доллараар өссөн дүн юм.

Тэгвэл хөрөнгө оруулагчид ямар металл руу хошуурч байна вэ. Хайгуулын зардлыг задалбал алт илт өнгөлж байна. Шар металлын зардал нийт санхүүжилтийн бараг 50 хувийг “залгиж” буй аж. Харин алтны араас зэс бичигдэж байна. Өнгөрсөн онд зэсийн хайгуулд нийт 1.6 тэрбум ам.доллар зарцуулсан

нь нийт хөрөнгө оруулалтын 8-9 хувийг эзэлсэн байна. Мөн шинэ эрин үеийн таваар гэгдэж буй батарейн түүхий эдүүд уламжлалт эрдсүүдтэй уралдан хөрөнгө татаж байгаа аж.

Өнгөрсөн сарын 30-ны байдлаар Монгол Улсад хайгуулын 1537 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн өргөдлийн журмаар олгож болдоггүй юм уу хэмээн хувийн хэвшилээс асууж байна. Хариуд нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сүмъяабазар өрсөлдөөн бий болсноор Монголд ирэх өгөөж нь илүү нэмэгдэнэ хэмээн хариулсан. Цаашид өргөдөл болон сонгон шалгаруулалтын хос сувгаар тусгай зөвшөөрөл олгох аж. Мөн уул уурхайн компаниуд хэдийнэ хариулсан. Цаашид өргөдөл болон сонгон шалгаруулалтын хос сувгаар тусгай зөвшөөрөл олгох аж. Мөн уул уурхайн компаниуд хэдийнэ хариулсан. Цаашид өргөдөл болон сонгон шалгаруулалтын хос сувгаар тусгай зөвшөөрөл олгох аж. Мөн уул уурхайн компаниуд хэдийнэ хариулсан. Цаашид өргөдөл болон сонгон шалгаруулалтын хос сувгаар тусгай зөвшөөрөл олгох аж.

Монгол Улсын стратегийн ордууд болон гол зам, дэд бүтцийг зангиддаг “Эрдэнэс Монгол” газрын тос болон газрын ховор элементийн шинэ нэгж байгуу-

лахаар төлөвлөж байгааг тус компанийн гүйцэтгэх захирал П.Ганхүү мэдэгдлээ. Түүнчлэн тус компанийг Үндэсний баялгийн сан болгохоор төлөвлөж байгаа аж.

“Эрдэнэс Монгол”-ыг үндэсний баялгийн сан болгоно

Сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол Улсын нийт экспортын 80-аас дээш хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн, үнэт металлын экспорт бүрдүүлж байна. Гэвч эрдэс бүтээгдэхүүнийг худалдаалж байгаа дундаж үнэ бусад орны таваарын бирж дээрх ханшнаас хэд дахин доогуур үнэлэгдсэний улмаас ашигт малтмал үнэгүйдсэн хэвээр. 2005-2017 оны хооронд нүүрсний экспортын биет хэмжээ 15 дахин нэмэгдсэн. Нүүрсний орлого нэрлэсэн дүнгээр 26 сая ам.доллараас 2.2 тэрбум ам.доллар

хүртэл 85 дахин өсчээ. Гэвч манай улсын эдийн засаг, монгол айл өрхийн орлого ингэж өсөөгүй. Тиймээс бодит үнэ бий болгох түүхий эдийн бирж байгуулахаар төлөвлөж байна. Тус биржийг “Эрдэнэс Монгол” компани хариуцан байгуулах аж.

Олон улсын зах зээлд зэсийн ханш 20 хувиар унаж, хөрөнгө оруулагчдыг цочоосон ч манай зэсийн төслүүд амжилттай урагшилж байна. Уул уурхайн хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр мэргэшсэн компани “Лайон Менежер”-ийн захирал Вэдди Виддат “Одоогийн байдлаар уул уурхайн мөчлөг сайжрах шатандаа яваа ч энэ салбарт хангалттай хөрөнгө ирээгүй” гэж мэдэгдлээ. Монгол шиг орны хувьд хайгуул, ашиглалтын салбарт хөрөнгө оруулалт татахад ихээхэн боломж бий ч хөрөнгө оруулагчид эрсдэлийг ихээхэн анхаарах болсныг тэрбээр сануулав. Уул уурхай өсөх мөчлөгийнхөө өмнө ирсэн. Харин энэ үеийг Мөн Алтан нар, Баянхөндий хөрөнгө оруулагчдын ярианаас харж болохоор байлаа. [ЗГМ]

онцолж байна.

Монгол Улс ирэх 10-15 жилд уул уурхайгүйгээр урагшлахгүй нь тодорхой болсон. Тиймээс энэ салбарт тулгарч буй сорилтуудыг шуурхай шийдэж, ойлголтоо нэгтгэхэд шил шилээ даран болж буй чуулга уулзалтууд чухал үүрэгтэй хэмээн салбарынхан үзэж байгаа юм. Эс бөгөөс энэ салбарыг тойрсон нийгэм, улс төр, байгаль орчны асуудлууд улам хурцдаж мэдэхээр байна.

2010 оны эхэн шиг Монгол руу мөнгөө цутгахаар хөрөнгө оруулагчид дугаарлан зогсоогүй ч манай улсыг сонирхсоор байна. Уул уурхай бол ухаж олборлодог салбар гэсэн ойлголт ард хоцорч, уул уурхайг дэд бүтэц ложистикийн өнцгөөс харах хандлагатай болжээ. Уул уурхайн чуулганд оролцогчдын тоо, тайлан мэдээллээс харахад Монголын уул уурхайн дахин сэргэлт иржээ. Гэхдээ унаж босож, уруудаж өгсөж үзсэн хашир хийгээд хариуцлагатай уул уурхай эргэн сэргэж буйг сайд дарга нараас эхлээд хувийн хэвшил хөрөнгө оруулагчдын ярианаас харж болохоор байлаа. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

Гол төслүүд хэрхэн урагшилж байна вэ?



Kincora Copper компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Сэм Спринг



Xanadu Mines Limited компанийн гүйцэтгэх захирал Эндрю Стюарт



Erdene Resource Development компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Питер Акерли



Orana Mining компанийн Геологийн асуудал эрхэлсэн дэд ерөнхийлөгч Жилборт Штейн

Хүрэл үнэг талбайд эрдэсжилт өндөртэй шинэ хэсгүүдийг илрүүлсэн. Уг талбайн West Kasulu хэсгийн шин

Эдийн засаг

Ипотекийг эрчимжүүлэх иргэдийн хүлээлт өндөр байна

Ипотекийн зээлийн шинэ журмыг энэ сард танилцуулна

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Н.Алтанхуягийн Засгийн газар 2013 онд эрс шийдмэг гэгч нь эхлүүлж байсан найман хувийн хүүтэй ипотекийн зээл тав дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Гэвч иргэдээ орон сууцжуулах хамгийн боломжит хувилбар эх үүсвэрийн гацаанд орж, урьдчилгаа 30 хувиа бүрдүүлэх итгэл өвөртөлж яваа олон хүний урам зориг хугарахад хүрээд байна.

Арилжааны зарим банк иргэдээс зээлийн хүсэлт авахаа энэ сараас зогсоож, дор бүрнээ санхүүжилт харуулдаж сууна. Монголбанк, Засгийн газар хамтран хэрэгжүүлж эхэлсэн дээрх хөтөлбөрийн үр дүнд өдгөө 93 орчим мянган иргэн орон сууцны зээлд хамрагдаж, хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх сэдлийг улам өрсдөн билээ. Гэвч он гарснаас хойш ипотекийн санхүүжилт хумигдаж, ердөө 2000 гаруй иргэн уг зээлд хамрагдаж чадсан байна.

Монголбанк долдугаар сард гэхэд дөнгөж 15.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 231 зээлийн хүсэлтэд олгохоор арилжааны банкуудад хуваарилсан байх жишээтэй. Он гарснаас хойш тус санхүүжилтэд нийт 150 орчим тэрбум төгрөгийг Засгийн газар, Монголбанк олгожээ. Үүний 96.2 тэрбум төгрөгийг төв банкнаас олгоод байгаа юм. Харин Засгийн газрын санхүүжилт дорвитой нэмэгдсэнгүй. Үүнээс болоод өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад ипотекийн



С.Батсайхан / ЗГМ©

зээлийн хүртээмж тааруухан гүйцэтгэлтэй байна.

● **Арилжааны зарим банк иргэдээс зээлийн хүсэлт авахаа энэ сараас зогсоож, дор бүрнээ санхүүжилт харуулдаж сууна.**

● **Он гарснаас хойш орон сууцны санхүүжилтэд нийт 150 орчим тэрбум төгрөгийг Засгийн газар, Монголбанк олгожээ.**

● **Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд 2013-2017 онд борлуулалт хоёр дахин нэмэгдсэн.**

Уг нь энэ онд хамгийн багадаа шинээр 5000 иргэнд ипотекийн зээл олгох нөхцөлийг бүрдүүлнэ гэдгээ Засгийн газар оны эхэнд амлаж байлаа. Тодруулбал, төсвөөс 120 тэрбум төгрөг, Монголбанкны зээлийн эргэн төлөлтөөс 180 тэрбум төгрөгийг ипотекийн санхүүжилт болгохоо мэдэгдэж байсан юм. Үлдсэн хугацаанд санхүүжилт нэмэгдэж, банкууд ипотекийн зээл олголтоо эрчимжүүлэхгүй бол 2017 оныхоос хоёр дахин бага иргэн байртай болохоор байна. Сангийн яам ипотекийн зээл олгох санхүүжилтээ амсуулах төдий байгаа нь эргээд ипотека хумигдах эрсдэл бий болгож байгаа юм. Нийслэлийн агаар болон хөрсний бохирдлыг шийдвэрлэх хамгийн оновчтой гарц нь ипотека гэж үзэж байгаа энэ цаг үед уг зээлд санхүүжилт ус, агаар мэт хэрэгтэй байна.

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-г манай улс хамрагдсантай хол-

богдуулан ипотекийн зээлийн хөтөлбөрийг төсвийн шинжтэй санхүүжилт гэж үзсэн. Тиймээс уг зээлийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлэхийг хязгаарласан нь зээлийн эрч саарахад хүргэсэн. Тэгвэл энэ сард төв банк Засгийн газарт найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг бүрэн хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлаа хангаж байна. Ирэх сараас ипотекийн зээлийн “ирээдүй”-г Засгийн газар дангаар хариуцаж эхлэх юм. Үүний өмнө “Ипотекийн зээлийн ерөнхий журам”-д өөрчлөлт оруулахаар Засгийн газар, Монголбанкны хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд шинэ журам удахгүй бэлэн болох юм байна. Иргэдийн дунд хүлээлт үүсгээд байгаа байрны урьдчилгааг бууруулах буюу 20 хувь болгох Засгийн газрын санаачилга шинэ журмаар тодорхой болох нь.

Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгөөр хэмжигдэж

байгаа бол нийт зээлийн үлдэгдлийн 17.6 хувийг орон нутагт олгосон зээл эзэлжээ.

Орон сууцны зээл олголт ийнхүү удаашрах хэрээр түрээсийн байрны үнэ нэмэгдэж, компани иргэн хоорондын хувь зээл “цэцэглэж” байгаа нь нууц биш.

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд 2013-2017 онд орон сууцны борлуулалт хоёр дахин нэмэгдсэн. Тэгвэл энэ онд зах зээл дээр ашиглалтад орсон бэлэн байрны борлуулалт 40 хувиас хэтрэхгүй байна. Хэдий тийм боловч ирэх жилүүдэд орон сууцны нийлүүлэлт нэмэгдэхээр байна. Нийслэлд гэхэд нийт 60 гаруй мянган айлын орон сууцны төсөл хэрэгжиж байгаагаас энэ онд болон ирэх онд ашиглалтад орох 7.4 мянган орон сууц байгаа аж. Дээрх хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн жил хамгийн их орон сууц борлуулалдсан ба түүний

63 хувьд шинээр ипотекийн зээл олгосон байдаг. Өнгөрсөн онд борлуулсан орон сууцны 44 хувийг ипотекийн зээл санхүүжүүлсэн бол уг үзүүлэлт энэ онд буурч мэдэхээр байна.

ДНБ-д эзлэх ипотекийн зээлийн хэмжээ манай улсад дэлхийн дунджаас бага байгаа. Тэрчлэн улсын хэмжээнд насанд хүрсэн хүн амын дунд 25-29 насныхан хамгийн их хувийг эзэлж байгаагаас гадна 216 мянган өрх гэр хороололд амьдарч байна. Ирэх таван жилд орон сууцны зээлийн эрэлт өснө гэж зарим судалгааны байгууллага мэдээлж буй. Энэ үед Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд өөрчлөлт орж байна. Хоёр жилийн өмнө тус журамд өөрчлөлт оруулж байсан. Өнгөрсөн онд ипотекийн зээл олголт 2016 онтой харьцуулахад 20 гаруй хувиар буурч байв. Тэгвэл энэ онд дахин буурах эрсдэл бас байна. [ЗГМ]

САНХҮҮ

Хөгжиж буй орнуудын зах зээл анх удаа урт хугацаанд буурлаа

Хөгжиж буй орнуудын зах зээл 2008 оны санхүүгийн хямралаас хойш анх удаа хамгийн урт хугацаанд буурлаа. Энэхүү уналтад АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан, АНУ мөнгөний бодлогоо чангатгах хүлээлт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн гэж шинжээчид үзэж байна. Мөн Туркийн лирийн ханш суларч, Аргентин өрөө буцаан төлөхөд сорилттой тулгарсан нь тодорхой нөлөө

үзүүлснийг шинжээчид онцолж байна. АНУ мөнгөний зөөлөн бодлого баримталж байх үед хөрөнгө оруулагчид хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулж, өндөр өгөөж хүртэх сонирхолтой байсан аж.

Харин ам.долларын ханш чангарснаар энэ хандлага буурчээ. Үүнээс өмнө 2013-2015 онд хөгжиж буй орнуудын эдийн засаг саарахад үүнтэй ижил явдал давтагдаж байсан юм.

УУЛ УУРХАЙ

Нүүрсний салбарын шилдгүүдийг санал асуулгаар тодрууллаа

Б.Бямбасүрэн
Шинжээч

Хоёр өдөр үргэлжилсэн “Coal Mongolia-2018” арга хэмжээ өндөрлөж, шилдгүүдээ шалгарууллаа. Нүүрсний салбарын “Шилдгийн шилдэг” буюу Гран при шагналыг 2018 оны эхний долоон сарын байдлаар 5.5 сая тонн нүүрс олборлосон “Energy Resource” компани хүртэж, “Алтан уурхайчин” цомын эзэн боллоо. Харин



“Шилдэг гэрээт олборлолтын компани”-аар “Thiess Mongolia” компани тодорсон байна.

“Шилдэг техник, технологи нийлүүлэгч компани”-д таван компани өрсөлдөж “Wagner Asia”

шалгарлаа.

67 компани үзэсгэлэн гаргаснаас “United Belaz Machinery” компани шилдэг үзэсгэлэн гаргагчаар тодорч “Алтан уурхайчин” цом хүртсэн юм. Харин “Шилдэг бүтээмж”-ийн шагналыг нүүрсний нөөцөө нэг тэрбум тонноор нэмэгдүүлсэн “Эрдэнэ Тавантолгой” компани хүртлээ. Найм дахь удаагийн “Coal Mongolia” чуулганы шилдгүүдийг шалгаруулахдаа олон нийтийн саналыг тусгаснаараа онцлогтой юм.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:							
АПУ ХК		ГОВЬ ХК		ТАВАН ТОЛГОЙ ХК		СҮҮ ХК	